**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

“Эрчим хүчний төсөл 2”-ын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** СНАГ-2025/040/НА-СТА-ТХН


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br><br>Улаанбаатар хот<br>2025 он | Санхүү, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор : Ц.Наранчимэг<br>Утас: 51-261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Б.Долгорсүрэн<br>Утас: 51-261885 Цахим хаяг: dolgorsurenb@audit.gov.mn<br><br>Аудитор: Н.Нямсүрэн<br>Утас: 51-261628 Цахим хаяг: nyamsurenn@audit.gov.mn<br><br>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Ди Эй Би Жи Аудит ХХК-ийн захирал Н.Дэлгэрмаа<br>Утас: 976-91910954 Цахим хаяг: dabg.audit@gmail.com |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 07/782
танай ____________-ны №____________-т

“ЭРЧИМ ХҮЧНИЙ ТӨСӨЛ 2”-ЫН ЗОХИЦУУЛАГЧ Д.ГАНБААТАР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу “Эрчим хүчний төсөл 2”-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдөрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Төслийн хэрэгжилт, гүйцэтгэлийн үр дүнгийн хаалтын тайлан боловсруулах 210,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч төслийн хугацааг 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдөр хүртэл сунгасан тул хойшлогдсон байна.

**Аудитын гол асуудал**

Ховд аймгийн Мянгад суманд 10 МВт чадалтай Нарны цахилгаан станц барьсан гүйцэтгэгч Япон улсын KCCS компани Ковид-19 цар тахлын үеийн нэмэгдэл зардлын 351.3 мянган ам.доллар, гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын 757.0 мянган ам.долларыг төслөөс нэхэмжилсэн.

Дэлхийн банкнаас зөвшөөрсний дагуу Эрчим хүчний яамны Гэрээ, эрх зүйн газраас Маргаан таслан шийдвэрлэх ажлын хэсэг томилогдон ажиллаж, гаалийн болон импортын нэмэгдсэн өртгийн албан татварын 326.0 мянган ам.долларыг Япон улсын KCCS компанид, дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын 431.0 мянган ам.долларыг Татварын ерөнхий газарт тус тус шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Z:\Yawsan_Bichig\2025\0225 SNAG-96.Docx

1525000401

Ажлын хэсгээс Ковид-19-тэй холбоотой 351.3 мянган ам.долларын нэмэлт зардлыг нэмж төлөхгүй гэсэн шийдвэр гаргасан боловч шийдвэр оройтож гарснаас 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрөөс өмнө гүйлгээ хийж амжихгүй болж, тус төлбөрийг Дэлхийн банканд буцаан төлөх эрсдэл үүссэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

Z:\Yawsan_Bichig\2025\0225 SNAG-96.Docx

## Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **7,780,554,156.28** | **1,089,778,808.94** |
| 31 | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **7,780,074,156.28** | **1,089,298,808.94** |
| 312 | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **7,780,074,156.28** | **1,089,298,808.94** |
| 3121 | **Төгрөг** | **496,960,912.79** | **1,089,116,737.86** |
| 31210 | Төрийн сангийн харилцах | 496,960,912.79 | 1,089,116,737.86 |
| 3122 | **Гадаад валют** | **7,283,113,243.49** | **182,071.08** |
| 31221 | Төрийн сангийн харилцах | 7,283,113,243.49 | 182,071.08 |
| 33 | **АВЛАГА** | **480,000.00** | **480,000.00** |
| 335 | **Бусад авлага** | **480,000.00** | **480,000.00** |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 480,000.00 | 480,000.00 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **46,219,125.49** | **10,493,331.16** |
| 392 | **Үндсэн хөрөнгө** | **46,219,125.49** | **10,493,331.16** |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 168,636,364.00 | 168,636,364.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (145,214,646.74) | (168,636,363.96) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж (компьютер) | 74,893,023.00 | 74,893,023.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (57,184,502.86) | (67,261,578.62) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 19,273,597.00 | 19,273,597.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (14,184,708.91) | (16,411,710.26) |
| 393 | **Биет бус хөрөнгө** | **-** | **-** |
| 39301 | Программ хангамж | 5,909,090.90 | 5,909,090.90 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (5,909,090.90) | (5,909,090.90) |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **7,826,773,281.77** | **1,100,272,140.10** |
| 4 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **7,826,773,281.77** | **7,826,773,281.77** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | **7,826,773.281.77** | **7,826,773,281.77** |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 7,826,773,281.77 | 1,100,272,140.10 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 13,144,009,671.01 | 7,826,773,281.77 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (5,317,236,389.24) | (6,726,501,141.67) |
| 5 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **7,826,773,281.77** | **1,100,272,140.10** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **46,329,728,308.04** | **21,668,110,610.55** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **46,329,728,308.04** | **21,668,110,610.55** |
| 120 | **Нийтлэг татварын бус орлого** | **46,329,728,308.04** | **21,668,110,610.55** |
| 120044 | Зээлийн санхүүжилт | 21,886,222,984.84 | 20,373,050,109.48 |
| 120009 | Бусад орлого | 4,250,000.00 | - |
| 122004 | Тусламжийн орлого | 24,439,255,323.20 | 1,295,060,501.07 |
| 2 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **27,200,720,336.36** | **28,375,735,689.88** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **27,200,720,336.36** | **28,375,735,689.88** |
| 210 | **Бараа, ажил үйлчилгээний зардал** | **27,200,720,336.36** | **28,375,735,689.88** |
| 210101 | Үндсэн цалин | 433,796,572.00 | 417,529,621.17 |
| 210201 | Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал | 53,218,732.00 | 49,367,949.51 |
| 2103 | **Байр ашиглалтын тогтмол зардал** | **51,183,439.00** | **51,639,053.36** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,427,839.00 | 639,053.36 |
| 210304 | Түрээсийн зардал | 49,755,600.00 | 51,000,000.00 |
| 2104 | **Хангамж, бараа материалын зардал** | **9,900,034.93** | **16,709,525.35** |
| 210401 | Бичиг хэргийн материал | 6,813,389.00 | 12,585,400.00 |
| 210403 | Шуудан холбооны зардал | 1,286,645.93 | 1,724,125.35 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 1,800,000.00 | 2,400,000.00 |
| 2106 | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **25,991,556.00** | **52,602,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 25,991,556.00 | 52,602,000.00 |
| 2107 | **Томилолт зочны зардал** | **135,692,671.00** | **202,187,021.17** |
| 210702 | Дотоод албан томилолтын зардал | 135,692,671.00 | 202,187,021.17 |
| 2108 | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал** | **46,486,513.95** | **107,893,234.57** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээ | 29,415,448.00 | 80,894,910.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 16,363,635.00 | 21,818,181.82 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | - | 4,196,830.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 190,713.00 | 190,713.00 |
| 210808 | Банкны үйлчилгээний хураамж | 516,717.95 | 792,599.75 |
| 2109 | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **26,444,450,817.48** | **27,477,807,284.75** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,400,616,026.48 | 27,442,081,490.43 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал | 43,834,791.00 | 35,725,794.32 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН** | **19,129,007,971.68** | **(6,707,625,079.33)** |
| 4 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО** | **221,530,409.48** | **4,072,864.99** |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз | 221,530,409.48 | 4,072,864.99 |
| 5 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ** | **24,667,774,770.40** | **22,948,927.33** |
| 225001 | Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз | 228,519,447.20 | 22,948,927.33 |
| 225012 | Хөрөнгө оруулалтаар бэлтгэгдсэн шилжүүлэх зориулалттай хөрөнгийн зардал | 24,439,255,323.20 | - |
| 6 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН** | **(5,317,236,389.24)** | **(6,726,501,141.67)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **11,733,869,310.50** | **21,668,110,610.55** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **11,733,869,310.50** | **21,668,110,610.55** |
| 120 | **Төсөвт байгууллагын өөрийн орлого** | **11,733,869,310.50** | **21,668,110,610.55** |
| 120044 | Зээлийн хөрөнгөөр санхүүжсэн орлого | 11,729,619,310.50 | - |
| 120009 | Бусад орлого | 4,250,000.00 | 20,373,050,109.48 |
| 122004 | Тусламжийн орлого | - | 1,295,060,501.07 |
| 2 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **117,208,696.00** | **-** |
| 21 | **Бараа, ажил үйлчилгээний бусад зардал** | **117,208,696.00** | **-** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж | 117,208,696.00 | - |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **11,616,660,614.50** | **21,668,110,610.55** |
| 22 | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | | |
| 220001 | Барилга байгууламж | - | 3,503,230,392.99 |
| 4 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН** | **-** | **3,503,230,392.99** |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **(3,503,230,392.99)** |
| 6 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| 14 | **Бусад эх үүсвэр** | **-** | **4,072,864.99** |
| 145001 | Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз | - | 4,072,864.99 |
| 23 | **Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл** | **16,883,657,390.10** | **24,836,779,502.57** |
| 232001 | Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл | 16,883,657,390.10 | 24,836,779,502.57 |
| 25 | **Санхүүгийн үйл ажиллагааны зардал** | **6,884,823.06** | **22,948,927.32** |
| 250001 | Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз | 6,884,823.06 | 22,948,927.32 |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(16,890,542,213.16)** | **(24,855,655,564.90)** |
| 8 | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(5,273,881,598.66)** | **(6,690,775,347.34)** |
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **13,053,955,754.94** | **7,780,074,156.28** |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **7,780,074,156.28** | **1,089,298,808.94** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **13,144,009,671.01** | **13,144,009,671.01** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **13,144,009,671.01** | **13,144,009,671.01** |
| Тайлант үеийн үр дүн | | (5,317,236,389.24) | (5,317,236,389.24) |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **7,826,773,281.77** | **7,826,773,281.77** |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | |
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **-** | **7,826,773,281.77** | **7,826,773,281.77** |
| Тайлант үеийн үр дүн | | (6,726,501,141.67) | (6,726,501,141.67) |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **-** | **1,100,272,140.10** | **1,100,272,140.10** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн гүйцэтгэлийн тайлан

*2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| **2** | **Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн** | **29,768,100,000.00** | **28,340,009,895.56** | **1,428,090,104.44** | **95.2** |
| **22** | **Хөрөнгө оруулалтын зардал** | **4,500,000,000.00** | **3,503,230,392.99** | **996,769,607.01** | 77.8 |
| 220001 | Барилга байгууламж | 4,500,000,000.00 | 3,503,230,392.99 | 996,769,607.01 | 77.8 |
| **23** | **Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл** | **25,268,100,000.00** | **24,836,779,502.57** | **431,320,497.43** | **98.3** |
| 232001 | Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл | 25,268,100,000.00 | 24,836,779,502.57 | 431,320,497.43 | 98.3 |
| **1** | **Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр** | **29,768,100,000.00** | **21,668,110,610.55** | **8,099,989,389.45** | **72.8** |
| **120** | **Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас** | **29,768,100,000.00** | **21,668,110,610.55** | **8,099,989,389.45** | **72.8** |
| 120044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | 25,268,100,000.00 | 20,373,050,109.48 | 4,895,049,890.52 | 80.6 |
| 122004 | Тусламжийн эх үүсвэрээс санхүүжих | 4,500,000,000.00 | 1,295,060,501.07 | 3,204,939,498.93 | 28.8 |
| 3 | Тохируулсан орлогын дүн | | (18,876,062.33) | | |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 7,780,074,156.28 | | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 1,089,298,808.94 | | |
| **61** | **Байгууллагын тоо** | **1** | **1** | - | |
| **62** | **Ажиллагсадын тоо** | **10** | **10** | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9 | 9 | - | 100.0 |

## 3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

3.1. АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн дагуу мэдээллийг тогтоосон хугацаанд иж бүрэн байршуулаагүй 28,340,009.9 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, бусад хууль тогтоомжийг хэрэгжилттэй холбоотой Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад хуулийн хугацаанд ирүүлээгүй зөрчилд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Хариуцлага тооцох албан шаардлага | | Албан шаардлага | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Төслийн баталсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын 2024 оны 9, 10, 11 дүгээр сарын нийт 28,340,009.9 мянган төгрөгийн 3 мэдээг хугацаа хоцроож, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргаж, өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. | 1 | 28,340,009.9 | | | | | 1 | 28,340,009.9 |
| Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын байгууллагад хуулийн хугацаанд ирүүлээгүй, өмнөх зөвлөмжийн биелэлтийн явцын тайлангийн хамт 2024 оны 11 дүгээр сард хугацаа хоцроож ирүүлсэн байна. | 1 | - | | | 1 | - | | |
| **Дүн** | **2** | **28,340,009.9** | **-** | **-** | **1** | **-** | **1** | **28,340,009.9** |